



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 08

Сүхбаатар

**“Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар,
ёс зүйг эрхэмлэх жил” болгон
зарлах тухай**

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.4.3 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар төр төсвийн байгууллагын үйл ажиллагааны чадавхи, үр нөлөө, төрөөс иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2015 оныг аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйг эрхэмлэх жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, ажил албанахаа онцлог нөхцөл байдалд тулгуурлан бодлого зорилт дэвшүүлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн нийт байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хянах, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА